

**Үйлчилгээний
худалдаа ба
Монгол улсын
дижитал эдийн
засгийн
статистикийн
семинар**

**Улаанбаатар
2023 оны 3 дугаар
сарын 20-23**

Дэд хурал 13

**Харяат болон харьяат бусын
хоорондох үйлчилгээний гүйлгээг
хэмжих нь: онцгой тохиолдол**

Тээврийн үйлчилгээ

Тьерри Кулет

Агуулга

1. Танилцуулга ба тодорхойлолт
2. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ
3. Зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ
4. Тээврийн бусад туслах болон нэмэлт үйлчилгээ
5. Мэдээлэл цуглуулах жишээ

1. Танилцуулга

Тээвэр

- Уг гарын авлагад тээвэр гэдэг нь нэг эдийн засгийн харьяатуудын нөгөө эдийн засагт үзүүлж буй тээврийн бүх төрлийн үйлчилгээг хамарна гэж тодорхойлсон.
- Тээврийн хэлбэр тус бүр нь тодорхой багц саад, бэрхшээлийг учруулж байсан ч ерөнхий шинж чанарууд нь маш төстэй. Тийм ч учраас энэхүү дүн шинжилгээ нь функциональ ангилалд (ачаа тээвэр, зорчигч, тээврийн нэмэл үйлчилгээ) голчлон анхаарсан.
- Тээвэрт мөн энэ танилцуулгад тусгагдаагүй шуудангийн болон буухиа шуудангийн үйлчилгээ (ТТА6-д шинээр багтсан) орно.

Тээвэр (EBOPS)

- **3.1 Далайн тээвэрлэлт**
 - 3.1.1 Зорчигч
 - 3.1.2 Ачаа
 - 3.1.3 Бусад
- **3.2 Агаарын тээвэрлэлт**
 - 3.2.1 Зорчигч
 - 3.2.2 Ачаа
 - 3.3.3 Бусад
- **3.3 Тээвэрлэлтийн бусад хэлбэрүүд**
 - 3.3.1 Зорчигч
 - 3.3.2 Ачаа
 - 3.3.3 Бусад
- **3.4 Илгээмж, буухиа шуудан шуудангийн үйлчилгээ**

Тээврийн тодорхойлолт

- Тээврийг дараахь байдлаар ангилж болно :
 - **Тээврийн хэлбэр:** далай, агаарын болон бусад (төмөр зам, авто зам, дотоодын усан зам, дамжуулах хоолой, сансрын тээвэр, цахилгаан дамжуулах).
 - **Функциональ ангилал:** Тээвэрт зорчигч тээвэрлэх, бараа бүтээгдэхүүн тээвэрлэх (ачаа), Тээврийн хэрэгслийг хөдөлгөгч багийн хамт түрээслэх (захиалгат нислэг) зэрэг багтана.
 - Ачаа зөөвөрлөх хураамж, навигацийн хураамж, хадгалах, агуулах, чиргүүл гэх мэт **холбогдох туслах болон нэмэлт үйлчилгээнүүд** мөн багтсан болно.

2. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ

Ачаа тээвэрлэлтийн бүртгэлийн КОНВЕНЦИ

- **Ачаа нь барааны бүрэлдэхүүн хэсэгтэй нягт холбоотой**
 - Барааны экспорт, импортын ачаа тээшийг хэмжихэд экспортлогч эдийн засгийн гаалийн хил дээр барааг ФОБ үнэлгээгээр авч үзэх конвенци нөлөөлсөн.
 - Гаалийн хил хүртэлх ачааны бүх зардлыг экспортлогч гаргана гэж тооцох; түүнээс цаашхи ачаа тээшний бүх зардлыг импортлогч гаргана гэж үзнэ.
 - Үйлчилгээний импортын хувьд бүртгэгдсэн дүн нь харьяат-импортлогчдын харьяат бус тээвэрлэгчдэд төлсөн дүн байна.
 - Үйлчилгээний экспорт хэмээн бүртгэгдсэн дүн нь харьяат бус-импортлогчдын харьяат-тээвэрлэгчдэд төлсөн дүн юм.

Ачаа тээвэрлэлт бүртгэлийн конвенци

- Тээврийн зардлыг хүргэлтийн нөхцлөөс хамааран импортлогч шууд болон шууд бусаар төлж болно
 - Шууд төлбөр нь тээврийн нэхэмжлэхтэй нийцсэн.
 - Шууд бус төлбөр (маршрут өөрчлөгдөх) нь тээврийн хөдөлгөөний зардлыг барааны СИФ үнээс ангид авч үзэх явдал юм.
- Хүргэлтийн нөхцлүүд
 - Ex-works,
 - FOB
 - СИФ
 - DDP ...

**2.1. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ:
олон төрлийн тохиолдолд ашиглах нь**

Ангилагч улсаас санал болгож буй ачаа тээвэрлэлт (1)

- Экспорттой холбоотой ачаа тээврийн үйлчилгээ үзүүлдэг

- Харьяат-экспортлогчийн нэрийн өмнөөс (СИФ гэрээ)

- Бүх зардлыг багтаасан нөхцөлтэй борлуулсан бараа; тээврийн зардлыг экспортлогч төлнө (Х/Х)
- Тээврийн зардлыг импортлогч руу дахин хуваарилна
- Шууд бус төлбөр

Үйлдвэрлэгч ®  Экспортлогч ®  Импортлогч (РБ)



- Харьяат бус-экспортлогчийн нэрийн өмнөөс(ФОБ гэрээ)

- Тээврийн зардлыг импортлогч төлнө (Х/ХБ)

Үйлдвэрлэгч ®  Импортлогч (ББ)

- Шууд төлбөр

Ангилагч улсаас санал болгож буй ачаа тээвэрлэлт (2)

- **Импорттой холбоотой үзүүлж буй ачаа тээврийн үйлчилгээ**
 - харьяат-экспортлогчийн нэрийн өмнөөс (СИФ гэрээ)
 - Бүх зардлыг багтаасан нөхцөлтэй борлуулсан бараа; тээврийн зардлыг экспортлогч төлнө (X/X)
 - Тээврийн зардлыг импортлогч руу дахин хуваарилна
- Үйлдвэрлэгч ®  Экспортлогч (ХБ)  Импортлогч (Х)
- Шууд бус төлбөр
- харьяат бус-экспортлогчийн нэрийн өмнөөс (ФОБ гэрээ)
 - X/X
 - ТТ гүйлгээ биш

Ангилагч улсаас авч буй ачаа тээвэрлэлт (1)

- **Экспорттой холбоотойгоор олж авсан ачаа тээврийн үйлчилгээ**

- **Харьяат -экспортлогчийн нэрийн өмнөөс (СИФ гэрээ)**


- Бүх зардлыг багтаасан нөхцөлтэй борлуулсан бараа; тээврийн зардлыг экспортлогч төлнө (ХБ/Х)
- Тээврийн зардлыг импортлогч руу дахин хуваарилна

Үйлдвэрлэгч (РБ)  Экспортлогч ®  Импортлогч (ХБ)



- Шууд бус төлбөр

- **Харьяат бус-экспортлогчийн нэрийн өмнөөс (ФОБ гэрээ)**

- харьяат бус-импортлогч тээврийн зардлыг төлнө (ХБ/ХБ)

Үйлчилгээ үзүүлэгч (ХБ)  Импортер (ХБ)

Ангилагч улсаас авч буй ачаа тээвэрлэлт (2)

- **Импорттой холбоотойгоор олж авсан ачаа тээврийн үйлчилгээ**
 - **харьяат -экспортлогчийн** нэрийн өмнөөс (СИФ гэрээ)
 - Бүх зардлыг багтаасан нөхцөлтэй борлуулсан бараа; тээврийн зардлыг экспортлогч төлнө (ХБ/ХБ)
 - Тээврийн зардлыг импортлогч руу дахин хуваарилна
 - Үйлдвэрлэгч (ХБ)  Экспортлогч (ХБ)  Импортлогч (Х)
 - Шууд бус төлбөр
- **харьяат бус-экспортлогчийн** нэрийн өмнөөс (ФОБ гэрээ)
 - Импортлогч тээврийн зардлыг төлнө (Х/ХБ)
 - Шууд төлбөр

Ачаа тээврийн гүйлгээ

Non-resident carrier		Resident carrier	
Imports FOB	Imports CIF	Imports CIF	Imports FOB
<p>Recording of a transport expenditure (separate transport invoice): direct payment</p> <p>(4)</p>	<p>Recording of a transport expenditure (estimate of the transport included in the goods): indirect payment</p> <p>(6)</p>	<p>Nothing to be recorded in the BOP (R/R). The NR exporter is paid for the total amount of the invoice (goods + transport) and pays the carrier (receipt): need of an offsetting entry</p> <p>(8)</p>	<p>Nothing to be recorded in the BOP (R/R)</p> <p>(2)</p>
Exports FOB	Exports CIF	Exports CIF	Exports FOB
<p>Nothing to be recorded in the BOP (NR/NR)</p> <p>(1)</p>	<p>Nothing to be recorded in the BOP (NR/NR). The R exporter is paid for the total amount of the invoice (goods + transport) and pays the carrier (expenditure): need of an offsetting entry</p> <p>(7)</p>	<p>Recording of a transport receipt (estimate of the transport included in the goods): indirect payment</p> <p>(5)</p>	<p>Recording of a transport receipt (separate transport invoice): direct payment</p> <p>(3)</p>

Бичиглэлийг харилцан хаах: жишээ

- 1000 экспортын барааны хэмжээ нь СИФ гэрээний 50%, СИФ/ФОБ харьцаа 4% бол: 1000 нэхэмжлэлд 20 (500x0.04) тээврийн үйлчилгээ ногдоно гэсэн үг.
- Экспортлогч нь харьяат-бус тээвэрлэгчид 8-ыг урьдчилж төлсөн, 12 нь харьяат-тээвэрлэгчтэй хийсэн тээврийн баримттай тохирч байна гэж үзнэ; ТТ (ХБ /ХБ)-д тусгах ёсгүй 8-ын дүн нь ФОБ/СИФ хөрвүүлэлтийн хэсэг (8)-аар нөхөгдөнө.

	Credit	Debit
- Goods exports	980	
- Transportation		
• Record of payment		8
• Fobisation (of which R)	20 (12)	
(of which NR)	(8)	

**2.2. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ:
Олон улсын гүйлгээний тайлангийн
систем (ОУГТС)-ийг ашиглах**

Мэдээлэл цуглуулахад ОУГТС-ийг ашиглах нь

- ОУГТС-ийн мэдээлэл цуглуулах системийг ашиглан тайланг голчлон шууд тайлагнадаг компаниуд болон банкууд үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс хийдэг.
- Тайлан нь харьяат-тээврийн байгууллага болон харьяат-бус импортлогч хоёрын хооронд шууд болон мөн болон харьяат-бус импортлогч ба харьяат-тээврийн байгууллага хоёрын хооронд төлөгдсөн дүнг илэрхийлдэг.
- Гарын авлагад дурдсан зөвлөмжийг ашиглан гадаад худалдааны мэдээлэл, СИФ-ФОБ харьцаатай холбоотой гаалийн мэдээллээр **ФОБ-ФОБ утгыг тохируулна**. Уг тохируулга нь шууд төлсөн дүн дээр нэмэгддэг.

Тээврийн төлбөр тооцоо

- Тээврийн төлбөр тооцоо нь **дебитийн асуудалд** хамаарна:
 - ХБ тээвэрлэгчтэй **ФОБ импорттой** холбоотой тээврийн зардлын бүртгэлд (2.с)
 - Экспортлогч нь тээвэрлэгчид урьдчлан төлбөр төлдөг тул ХБ тээвэрлэгчтэй **экспортын СИФ** (2.b).
- Тээврийн төлбөр тооцоо нь **кредитийн асуудалд** хамаарна:
 - Импортлогч нь төлбөрийг харьяат тээвэрлэгчид шууд хийсэн тул **экспортын ФОБ**-тэй холбоотой төлбөрийн баримтын бүртгэлд (1.d).
 - ХБ нь харьяат тээвэрлэгчид төлдөг тул импортын СИФ-тэй холбоотой төлбөрийн баримтын бүртгэлд (1.a).
 - Гуравдагч орнуудын хоорондын худалдаа, тээвэрлэлттэй холбоотой үйлчилгээ.

Тээврийн төлбөр тооцоо (2)

	Баримт		Зардал	
	Бүртгэгдсэн үйл ажиллагаа	Эх үүсвэр	Бүртгэгдсэн үйл ажиллагаа	Эх үүсвэр
1-харьяат тээвэрлэгчид	XXX	ТБ	XXX	СИФ/ФОБ
a. Импортууд СИФ	XXX	СИФ/ФОБ	----	----
b. Экспортууд СИФ	----	----	----	----
c. Импортууд ФОБ	XXX	ТБ	----	----
d. Экспортууд ФОБ				
2-1-харьяат бус-тээвэрлэгчид	----	----	XXX	СИФ/ФОБ
a. Импортууд СИФ	XXX	СИФ/ФОБ	XXX	ТБ
b. Экспортууд СИФ	----	----	XXX	ТБ
c. Импортууд ФОБ	----	----	----	----
d. Экспортууд ФОБ				

- ТБ - төлбөрийн бүртгэл

- Бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоо эсвэл гүйлгээний « FOBisation »

2.3. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ: Худалдааны мэдээллийг Фобизаци болгож хөрвүүлэх

Бараа бүтээгдэхүүний гүйлгээ: СИФ-ээс ФОБ болгон хөрвүүлэх

- Тооцоолж, үйлчилгээний дансанд хуваарилах шаардлагатай **нэмэлт зардлын** нэг хэсэг нь нэхэмжлэлийн үндсэн дээр нэгтгэсэн бараа бүтээгдэхүүний гүйлгээнд багтана.
- Экспорт, импортын нэхэмжлэхийн үнэд багтсан тээврийн хэмжээ нь дараах тэгшитгэлийн дүнгээс бий болно (жишээ 15-р слайдыг үзнэ үү):

Тооцоолсон тээвэрлэлт = барааны нэхэмжлэхийн үнэ (1) х СИФ гэрээний эзлэх хувь (2) х СИФ-ФОБ харьцаа (3)

- (1) Гаалийн тайлан
- (2) Хүргэлтийн нөхцөл
- (3) Гаалийн байгууллагын тооцоо

СИФ-ФОБ харьцаа: Гаалийн мэдүүлгийг ашиглах

Статистикийн утга болон нэхэмжлэлийн утгыг хоёуланг нь тайлагнасан үед СИФ/ФОБ харьцааг экспорт, импортын хоёр утгыг харьцуулан тооцоолж болно (эх сурвалж: гаалийн байгууллага).

- **Нэхэмжлэлийн утга (IV):** СИФ экспорт болон ФОБ импортын гэрээний сонголтууд (тухайн ангиллыг гаргасан эдийн засгийн гадаад түншүүдийн хил дээрх үнэтэй нийцнэ).
- **Статистикийн утга (SV):** тухайн ангиллыг гаргасан эдийн засгийн хил дээрх утга.
- IV-ын SV-тай харьцах харьцаа нь онолын хувьд IV-д багтсан тээврийн болон даатгалын хураамжийн хувийг гаргаж өгдөг.

СИФ-ФОБ харьцаа: судалгааны хэрэглээ

Экспорт, импортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн **жилийн болон тохиолдлын судалгаа**: барааны нэхэмжлэлийн үнэд багтсан тээврийн зардлын мэдээллээр хангана.

- Түүврийн бүлэглэл : экспорт, импорт, түнш улс эсвэл бүс, тээврийн хэлбэр.
- Урьдчилан бөглөсөн асуулга: гүйлгээ хийсэн өдөр, бүтээгдэхүүн, гарал үүсэл, очих газар, хүргэх нөхцөл, нэхэмжлэхийн үнэ, статистикийн үнэ цэнэ.
- Санал асуулгын асуултууд нь: тээвэрлэлтийн хэлбэр, тээвэрлэгчийн харьяалал, тухайн улсын доторх тээвэрлэлтийн хэмжээ (1), олон улсын тээвэр (2), очих улсын доторх (3) тээвэрлэлтийн хэмжээ зэргийг хөндсөн.

СИФ-ФОБ харьцаа (3)


Импортын талаас жишээ авбал

- Урьдчилсан ажлын гэрээтэй (EXW) А улсын импортлогч нь зарчмын хувьд нийт тээвэрлэлтийн талаар гурван (1), (2) ба (3) мэдээлэлтэй байна.
- ФОБ гэрээтэй бол (2) ба (3) мэдээлэл

$$\text{EXW: } SV = \text{EXW} + (1) + (2)$$

$$\text{ФОБ: } SV' = \text{ФОБ} + (2')$$

$$\text{СИФ/ФОБ харьцаа} = (2) + (2') / SV + SV'$$



СИФ/ФОБ харьцааг түнш улс болон тээврийн төрлөөр тооцдог

2.4. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ: Судалгаа, мэдээллийн загварчлал

Ачаа тээврийн судалгаа

- Тээврийн аж ахуйн нэгжүүдийн судалгаа нь ихэвчлэн тохиолддог шиг гүйлгээний ихэнх хэсэг нь цөөн тооны компаниудад төвлөрдөг бол сайн сонголт байж болох юм.
 - Суурин тээвэрлэгчид экспортын ачааны мэдээллийг өгөх боломжтой
 - харьяат бус тээвэрлэгчдийн салбар эсвэл төлөөлөгч нь импортын ачааны мэдээллийг өгөх боломжтой
- Санал асуулгад импорт, экспорт болон бусад тээврийн талаарх мэдээллийг оруулах шаардлагатай, учир нь эдгээр гүйлгээг ТТ-д өөрөөр авч үзэх ёстой.
 - харьяат-операторуудын импортын тээвэрлэлтийг бүртгээгүй боловч харьяат бус-операторуудын олсон ачааг нэгтгэхэд шууд бусаар ашиглаж болно (дебит).
 - Экспортын тээвэрлэлт (зээл).

Ачаа тээвэрлэлтийн үнэд суурилсан мэдээллийн загварчлал

- Өөр нэг арга бол гадаад худалдааны статистик мэдээллээс олж авсан экспорт, импортын тоо хэмжээний мэдээлэлтэй хослуулах зохих ачааны тарифыг сонгох явдал юм.
- Энэ арга нь ихэвчлэн захиргааны мэдээлэлд тулгуурладаг бөгөөд маш олон зүйлс шаарддаг:
 - Үндэсний мөнгөн тэмдэгтээр тонн тутамд үр ашигтай ачааны тарифын (жагсаалтад ороогүй үнэ) нарийвчилсан мэдээлэл шаардлагатай.
 - Бараа бүтээгдэхүүний бүлэг тус бүрийн хувьд
 - Тээврийн хэлбэрээр
 - Гарал үүслийн бүс, очих газраар
- Тээвэрлэлтийн үнийг холбогдох худалдааны хэмжээтэй тохируулах нь маш хэцүү байж магадгүй юм.

5. Мэдээлэл цуглуулахтай холбоотой жишээ

Их Британийн ачаа тээврийн талаархи мэдээлэл цуглуулахтай холбоотой жишээ

- **Импортын тал**

- Экспортлогч орнуудын хил болон Их Британийн хилийн хоорондох тээвэрлэлтийн нийт зардлыг тодорхойлоход ашиглагдаж буй тоннын матрицад хэрэглэгдэх бараа бүтээгдэхүүнд СИФ-ФОб тохируулга (тонноор хэмжих, бараа, тээврийн төрөл, ачааны үнэ зэргийг ашиглан).
- Нийт ачааны импортын нэг хэсэг нь Их Британийн операторуудын тээвэрлэж байгаа хэсгийг тодорхойлохын тулд тээврийн операторуудаас судалгаа авдаг.
- Энэ хэсгийг гадаадын операторуудын импортын тээвэрлэлтийн үйлчилгээг авахын тулд нийт тээвэрлэлтээс хасч тооцно.

- **Экспортын тал**

- Судалгаанд хамрагдсан харьяат операторуудаас экспортын ачаа тээвэр болон хөндлөн хийсэн худалдааны төлбөрийн баримтыг авдаг.

Францын ачаа тээврийн талаархи мэдээлэл цуглуулахтай холбоотой жишээ

- Тээврийн мэдээллийг цуглуулахдаа компаниудын **шууд тайлан, судалгаанд** үндэслэнэ.
 - Томоохон харьяат компаниуд болон харьяат-бус операторуудын салбаруудаас бие даасан гүйлгээний шууд тайлагналыг нэхэмжлэхийн үндсэн дээр тогтмол хийдэг.
 - ЖДҮ-ийн судалгааг жил бүр хийдэг.
- Мэдээлэл илгээж буй компаниуд дараахь зүйлийг тайлагнана
 - Дебит талд: импортын ФОБ (Р-импортлогч нь РБ-тээвэрлэгчид төлсөн тохиолдолд) болон экспортын СИФ (Р экспортлогч нь РБ-тээвэрлэгчийг урьдчилан төлсөн тохиолдолд) импортын РБ- тээвэрлэгчтэй холбоотой үйл ажиллагаа.
 - Кредитийн тал дээр: Р-тээвэрлэгчдийн РБ-компаниудтай хийсэн үйл ажиллагаа нь ФОБ экспорт (РБ-импортлогч нь Р тээвэрлэгчид төлдөг), СИФ импорт (РБ-экспортлогч нь Р-тээвэрлэгчийн үйлчилгээг ашигладаг).

Францын ачаа тээврийн талаархи мэдээлэл цуглуулахтай холбоотой жишээ

- **ФОБ-ФОБ** утгыг тохируулахдаа гадаад худалдааны мэдээлэл, СИФ-ФОБ харьцаа, хүргэх нөхцөл, тээврийн янз бүрийн хэлбэрийн хувьтай холбоотой гаалийн мэдээллийг хоёуланг нь ашиглан хийдэг.
- **СИФ-ФОБ харьцааг** гаалийн байгууллагаас хийсэн судалгаагаар 4-5 жил тутамд тооцдог.
 - Экспортлогч, импортлогч 15 000 аж ахуйн нэгжийн түүвэр дээр үндэслэсэн.
 - Судалгаанд: тээврийн хэлбэр, тээвэрлэгчийн харьяалал, гарал үүслийн болон очих улс, хүргэлтийн нөхцөл, тээврийн зардлын хэмжээ зэрэг мэдээллийг цуглуулдаг.
 - Мэдээллийг шууд цуглуулах ба "*ФОБisation*" аргыг хослуулсан нь гэрээний төрлөөс үл хамааран импорт, экспортын бүх тохиолдлыг бүрэн хамрах боломжийг олгодог.

Баярлалаа